

БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛТ БА ХУВИЙН ХЭВШЛИЙН АЖ АХУЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

*Э.Наран**
*Ш.Амжилт***

БНХАУ-ын ӨМӨЗО бол Монгол Улстай 3193 км урт хилийн шугам (Хятад Монгол хоёр улсын хилийн шугамын 68 хувийг эзэлсэн) бүхий Хятадын хамгийн анхны буюу 1947 онд байгуулагдсан томоохон ӨЗО болно. Өвөр Монголын нутаг дэвсгэрийн талбай нь 1 сая 183 мянган км² Монгол Улсын нутаг дэвсгэрээс 383 мянган км²-ээр бага байдаг. Харин хүн амын хувьд 2004 оны байдлаар 24 сая (23843500) дөхөж, Монгол Улсын хүн амаас 10 дахин их болох гэж байна.

Нэг. ӨМӨЗО-ны эдийн засгийн хөгжилт

1. Түргэн хурдацтай хөгжиж байна.

ӨЗО байгуулагдсанаас хойш 50 гаруй жилийн хугацаанд түүний эдийн засаг, нийгэм бүх талаар хөгжсөн байна. Ялангуяа 1978 оны ХКН-ын XI их хурлын III бүгд хурлын дараахь хориод жилийн өөрчлөлт шинэчлэлт болон эдийн засгийн нээлттэй бодлого хэрэгжүүлсний үр дүнд ӨЗО-ны эдийн засаг нэлээд түргэн хөгжиж эхэлсэн юм. Гэхдээ хамгийн дурдууштай нь сүүлийн хэдэн жил Өвөр Монголын эдийн засаг түүхэндээ байгаагүйгээр түргэн хурдацтай хөгжиж байгаа явдал нь дотоод, гадаадынхны анхаарлыг татаж буй.

Олон улсын жишгээр нэг орны хүн нэг бүрд ногдох ДНБ нь 1000 ам.доллар, хотжилтын хэмжээ 30 хувь, хоёрдугаар аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин 40 хувьтай тэнцсэн үед түүний эдийн засаг түргэн хурдацтай хөгжих шатандаа орно. 2003 оноос эхлэн Өвөр Монголын энэ гурван үзүүлэлт 1000 ам.доллар, 44.7 хувь, 45.3 хувьд хүрсэн нь дээрх нөхцлийг нэгэнт бүрдүүлсэн байна. Хамгийн чухал нь Өвөр Монголын эдийн засгийн хөгжилтийн бодит байдал нь түүний түргэн хурдацтай хөгжлийн шатанд орсныг харуулж байна. Өвөр Монголын Статистикийн Газрын бүртгэлээр, 2001 онд ӨЗО-ны ДНБ нь 10 хувиар, 2002 онд 12 хувиар тус тус өсөв. 2003 онд ДНБ нь 209.3 тэрбум юаньд хүрч 16.3 хувиар өсч анх удаа бүх Хятадад эдийн засгийн өсөлтийн хэмжээгээрээ тэргүүн байрыг эзэлжээ.

2004 онд ӨЗО-ны ДНБ нь 271.2 тэрбум юаньд¹ хүрч, өнгөрсөн оныхоос 19,4 хувиар өсч, өсөлтийн хэмжээ нь бүх Хятадын 9.5 хувийн процентыг давж, хоёр жил дараалан бүх Хятадад тэргүүлсэн байна.

* Э.Наран - ӨМИС-ийн Хөрш орон судлалын хүрээлэн, доктор, профессор
** Ш.Амжилт - ӨМИС-ийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Энэ нь ӨЗО байгуулагдсан 1947 оныхоос 130 дахин, өөрчлөлт шинэчлэлтийн өмнөх 1978 оныхоос 13 дахин илүү байна. Хүн бүрд ногдох ДНБ нь бүх Хятадын 1000 ам.долларын дундаж хэмжээнээс давж, 2004 онд 1366 ам.долларт (11305 юань)² хүрч, 1947 оныхоос 30 дахин, 1978 оныхоос 9 дахин нэмэгдэв. Хятадын Баруун бус нутгийн 12 оронд тэргүүн байрыг эзэлжээ. Үүний дотор:

Нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбар (голдуу хөдөө аж ахуй) нэлээд түргэн хөгжиж 50.6 тэрбум юаний нэмэгдэл өртгийг биелүүлэн, 14 хувиар өсөв. Үр тарианы нийт хураалт 15 сая тоннд хүрч 10.6 хувь нэмэгдэв. Энэ нь Өвөр Монголын түүхэн дээр гуравдахь удаагийн их элбэг хураалт болсон. Мал аж ахуйн дотоод бүтцийн тохируулалт үр дүнтэй болж, нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбарт мал аж ахуйн эзлэх хэмжээ нь 43 хувьд хүрэв. 2004 оны малын тооллогоор малын нийт тоо толгой 92.74 саяд хүрч, өнгөрсөн оныхоос 16.1 хувь өсөв. Үүнд тариалах орны мал аж ахуй маш түргэн хөгжиж малын тоо толгой нь бүх орны малын нийт тоо толгойн 67 хувийг эзэлсэн байна.

Хоёрдугаар аж үйлдвэрлэлийн салбар (голдуу аж үйлдвэр) хөгжиж 131 тэрбум юаний нэмэгдэл өртгийг биелүүлээд 29 хувиар өсөв. Энэ нь өөрчлөлт шинэчлэлтээс нааш хамгийн түргэн өсөлттэй жил болсон юм. Аж үйлдвэрийн нэмэгдэл өртөг нь ӨЗО-ны ДНБ-ий 37.5 хувийг эзэлж бий. Энэ мэт аж үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг мэдэгдэхүйц дээшилснээр барахгүй, гол чухал аж үйлдвэрийн паркууд түргэн хөгжиж байна. Жишээлбэл Шэньхуа нүүрсний корпорацийн нүүрсийг тос болгох зэрэг томоохон ажлыг эхлүүлсэн буюу ашиглалтанд оруулаад байна.

Гуравдугаар аж үйлдвэрлэлийн салбарын хөгжилт түргэсч 88 тэрбум юаний нэмэгдэл өртгийг биелүүлэн 13 хувиар нэмэгдэв. Түүнд зам харилцаа тээвэр, арилжаа худалдаа, хүнсний бүтээгдэхүүн, аялал жуулчлал, бараа гүйлгээ зэрэг салбар нь нэлээд түргэн хөгжсөн байна. Мэдээллийн үйлчилгээ, гэр барааны хөрөнгө, өрхийн үйлчилгээний ажил урагштай хөгжиж байна.

2. Аж үйлдвэрлэлийн салбаруудын бүтэц сайжирч байна.

1947 онд ӨМӨЗО-ны эдийн засгийн нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбар (хөдөө аж ахуй), хоёрдугаар аж үйлдвэрлэлийн салбар (аж үйлдвэр), гуравдугаар аж үйлдвэрлэлийн салбаруудын (голдуу үйлчилгээ) нэмэгдэл өртөг ДНБ-д эзлэх хэмжээ нь 76.7: 7.1: 16:2-ын харьцаатай байсан, энэ нь нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбар зонхилох байр эзэлж байсныг харуулж байна. Өөрчлөлт шинэчлэлтийн эхний үеийн 1978 онд энэхүү харьцаа нь 32.7: 45.4: 21.9 болон хувирч, нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин буурч, хоёрдугаар аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин өсч, гуравдугаар

аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин мөн нэлээд өссөн байна. 20 жилийн дараа 1998 он гэхэд дээрх үзүүлэлт 28.7: 40.2: 31.1-ийн харьцаатай болж, нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин нэн буурч, гуравдугаар аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин нэлээд өссөн байна. 6 жилийн дараа 2004 он гэхэд дээрх үзүүлэлт нь 18.7: 49.1: 32.2-гийн харьцаатай³ болж, нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбарын хувийн жин улам их буурч, гурван төрлийн аж үйлдвэрлэлийн салбарын харьцаа мэдэгдэхүйц сайжирч (хүснэгтийг үз) “10-р 5 жилийн төлөвлөгөө (2001—2005)”-ний хугацаанд энэ харьцааг 20: 44: 36 болгох зорилтдоо дөхөж байна.

	1947 он	1978 он	1998 он	2003 он	2004 он	10-р 5 жил
Нэгдүгээр аж үйлдвэрлэлийн салбар %	76.7	32.7	28.7	19.5	18.7	20
хоёрдугаар аж үйлдвэрлэлийн салбар %	7.1	45.4	40.2	45.3	49,1	44
гуравдугаар аж үйлдвэрлэлийн салбар %	16.2	21.9	31.1	35.2	32.2	36

3. Санхүүгийн орлого ихээхэн нэмэгдэж хот хөдөөгийн оршин суугчдын амьдрал сайжирч байна.

2004 онд ӨЗО-ны санхүүгийн нийт орлого 36.314 тэрбум юаньд⁴ хүрч, жилийн төсвөө 120 хувиар биелүүлэв. Энэ нь 2003 оны 25.76 тэрбум юаниас 10.5 тэрбум буюу 40.7 хувиар өсч, сүүлийн 11 жилийн хамгийн өндөр хэмжээнд хүрч, санхүүгийн орлогын хэмжээ бүх Хятадад үргэлжлэн дээшилж 2003 онд Шиньжааныг давж, 2004 онд Гирын мужийг давж, бүх Хятадад 23-р байр эзлэв.

Санхүүгийн орлогын бүтэц тасралтгүй сайжирч, нийгмийн даатгал, ядуурлыг бууруулж гамшигдагсад туслах, шинжлэх ухаан технологи боловсрол, эм эмнэлэг эрүүл мэнд, ажиллагсдын цалин хөлс зэрэг гол зүйлийг баталгаатайгаар хангав. Хот хөдөөгийн оршин суугчдын амьдралын төвшин улмаар дээшлэв. Хот суурингийн оршин суугчдын хүн бүрийн дундаж цэвэр орлого 2003 оны 2010 юаниас 2004 онд 8200 юаньд хүрч 14 хувиар нэмэгдэж, малчин тариачны хүн бүрийн дундаж цэвэр орлого нь 2003 оны 2284 юаниас 2004 онд 2670 юаньд хүрч 13 хувиар өсөв.

Малжих тариалах орны татвар хураамжийн өөрчлөлт шинэ шатанд орж, 2004 онд бүх ӨЗО-ны 12 аймаг хотын 6 аймаг хотын тариалангийн татварыг чөлөөлж, бусад аймгийн тариалангийн татварын нормыг дунджаар 7 хувь байснаас 4 хувь хүртэл бууруулж малчин тариачны хүн бүрийн дундаж татварын дараасыг 60 хувиас дээш бууруулжээ. 2005 онд бүх Хятадын малжих тариалах орныг бүх төрлийн татвараас чөлөөлнө.

Ажлын байр олгох ба дахин ажлын байр олгох ажил эрчимтэй явагдаж, бүх ӨЗО-ны хот сууринд 240 мянган хүнд шинээр ажлын байр хангаж, хот суурингийн бүртгүүлсэн ажилгүйдлийн хэмжээг 4.7 хувь болов.

4. Өөрчлөлт шинэчлэлт ахиж, нээлттэй бодлого эрчимтэй хэрэгжиж байна.

Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн өөрчлөлт ба дахин зохион байгуулах ажил идэвхтэй ахиж, нийт хэмжээг нэмэгдүүлэн төрийн өмчлөлийн хувийг бууруулах зарчмын ёсоор Өвөр Монголын Цахилгаан Эрчим Хүчний Корпораци, Хуулин голын Нүүрсний Корпораци зэрэг 10 гол чухал аж ахуйн нэгжийг дахин зохион байгуулж 20 тэрбум юаний шинэ хөрөнгө оруулалт хийж хүчин чадал ба хөгжилтийн нөөц хүчийг нь нэмэгдүүлэв.

Нээлттэй бодлого хэрэгжүүлэх талаар “Гадагш явах” стратегийг идэвхтэй хэрэгжүүлж, “Умарш нээлт хийх” ажил чухал ахицтай болов. Орос, Монголын нөөц баялгийг хамтран нээх явдал нь бодитой ажил болж, Монгол Улсын Засгийн газар болон Оросын орон нутгийн засгийн газартай дээд хэмжээний уулзалт хийж ойлголцол итгэлцлээ гүнзгийрүүлэн, хамтын ажиллагаагаа өргөжүүлэв. “Оруулж ирэх” ажил илэрхий амжилт олж, 2004 онд ӨЗО-ны улсын дотоодын хөрөнгө оруулалт 70.2 тэрбум юанд хүрч, өнгөрсөн оныхоос 75 хувиар нэмэгдэв. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 600 сая ам.доллар оруулж, 60 хувиар нэмэгдэв. 2004 онд бүх ӨЗО-ны гадаад худалдааны нийт эргэлт 4 тэрбум 50 сая ам.долларт⁵ хүрч, өнгөрсөн оныхоос 31 хувиар нэмэгдэв. Үүнд экспортын хэмжээ 1.68 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оныхоос 17.4 хувь, импортын хэмжээ 2.37 тэрбум ам.долларт хүрч, 41.5 хувиар тус тус өссөн байна.

Өвөр Монголын газар зүйн байршлын давуу талаа ашиглан 2004 онд Орос, Монголтой хийсэн худалдааны хэмжээ 1.9 тэрбум ам.долларт хүрч, бүх ӨЗО-ны гадаад худалдааны нийт эргэлтийн 47 хувийг эзлэж, Орос, Монгол нь тус тус Өвөр Монголын нэгдүгээр, гуравдугаар худалдааны түнш болов.

Хил боомтын бүтээн байгуулалт эрчимжиж бараа дамжуулах хэмжээ 2004 онд 21.8 сая тоннд хүрч, 44 хувиар нэмэгдлээ. Эрээн боомтын бараа дамжуулах хүчин чадал 10 сая тоннд хүрч, 2004 онд 6.5 сая тонн бараа дамжуулав. Өвөр Монголын хилээр орж гарсан жуулчдын тоо 3 сая шахам болж, өнгөрсөн оныхоос 27 хувиар нэмэгджээ.

Хоёр. ӨМӨЗО-ны хувийн хэвшлийн эдийн засаг

Өнөөдөр Өвөр Монгол нь бүх Хятадын адил шинэ зууны эхний 20 жилд хөгжлийн хамгийн чухал боломжтой цаг үед хүрсэн бөгөөд хувийн хэвшлийн эдийн засаг ч гэсэн хөгжлийн нэн их орон зайтай

болсон байна.

Сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн аж ахуй түргэн хурдацтай хөгжиж ӨЗО-ны эдийн засгийн хөгжилтөд чухал байр суурь эзлэх болсон байна.

Одоогоор ӨЗО-ны хөрөнгө хүч, нөөцөөр харьцангуй томоохон аж ахуйн нэгжийн хагасаас дээш хувийг хувийн хэвшлийн аж ахуй эзэлж байна.

2003 оны байдлаар ӨЗО-ны хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо 35 мянга, ажил эрхлэгчдийн тоо 430 мянгад хүрсэн бөгөөд 7.5 сая хувийн жижиг үйлдвэр худалдааны нэгжүүдийн ажил эрхлэгчдийг оролцуулбал нийт 2 сая гаруй ажиллах хүчин хувийн хэвшлийн аж ахуйд ажил эрхэлж байна.

ӨЗО-ны хувийн хэвшлийн аж ахуй нь бүх ӨЗО-ны ДНБ-ий 25-аас⁶ дээш хувийг биелүүлж, ӨЗО-ны 101 хошуу шянь дүүргүүдийн дотор 40 орчим хошуу шянь дүүргүүдийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн төлсөн татвар нь тухайн орон нутгийнхаа 30—50 хувийг эзэлж байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд нь ӨЗО-ны гадаад худалдаанд нэн чухал байр суурь эзлэж байна. 2004 онд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн экспорт, импортын нийт хэмжээ нь 2.075 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оныхоос 46.2 хувиар нэмэгдэж, бүх ӨЗО-ны гадаад худалдааны нийт эргэлтийн 51.3 хувийг эзэлсэн байна. 2003 онд ӨЗО-ны хувийн хэвшлийн 27 аж ахуйн нэгж экспорт, импортын эрх авч, хувийн хэвшлийн 55 аж ахуйн нэгж бүтээгдэхүүнээ экспортолж байна.

Хувийн хэвшлийн эдийн засгийн нийт хэмжээ түргэн хурдацтай хөгжиж байгаа байдлыг дагалдан хувийн хэвшлийн эдийн засгийн аж үйлдвэрлэлийн бүтэц нь сайжирч байна. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд зөвхөн худалдаа, хоол хүнс, үйлчилгээний аж ахуй эрхэлдэг байснаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, зам тээвэр, экологийн бүтээн байгуулалт, эрчим хүч, барилга, худалдаа зэрэг өргөн хүрээнд аж ахуй эрхэлдэг болж байна. Жишээлбэл:

1. ӨЗО-ны Хөх хотын Мэнню корпорацийн 2003 оны сүүн бүтээгдэхүүний орлого 5 тэрбум юань, 2004 онд 7.2138 тэрбум юань⁷ болж, бүх Хятадын мөн салбарын хоёрдугаар байрыг эзэлж байна.

2. Бугат хотын “Тарган хурга” нэрэмжит гуанзны сүлжээ нь 1999 онд анх байгуулагдах үедээ эзлэх талбай нь 300 м² ч хүрэхгүй байсан хувийн жижиг гуанз, одоо бүх Хятадын газар сайгүй тархаж, жилийн орлого нь 2.5 тэрбум юаньд хүрч, улсад 80 гаруй сая юаний татвар төлж, жилд 30 гаруй мянган тонн хонины мах боловсруулсанаар мал аж ахуй, газар тариалан, боловсруулах, тээвэр зэрэг салбарын үйл ажиллагааг нэмэгдүүлжээ. “Тарган хурга” нь одоогоор тал нутгийн

онцлог болон монгол үндэстний идээ ундааны соёлыг харуулсан нэрт шошгын бүтээгдэхүүн болсон юм.

Үүнээс гадна, ӨЗО-ны гол 60 аж ахуйн нэгжийн дотор Дунда ямааны ноолуур, Чянькунь алт мөнгөний ХК болон Газрын ховор элементийн шинжлэх ухаан технологийн ХК зэрэг аж ахуйн нэгжүүд нь хувийн хэвшлийн эдийн засгийн хөгжлийг дайчилж байгаа төдийгүй мөн Өвөр Монголын эдийн засгийн өсөлтийн шинэ чухал хүчин болж байна.

Гурав. Оршиж байгаа асуудал ба шийдвэрлэх арга хэмжээ

Өвөр Монголын эдийн засгийн түргэн хөгжилт ба хувийн хэвшлийн аж ахуйн өргөжин хөгжих, жич түүний ӨЗО-ны нийгэм, эдийн засагт оруулж байгаа хувь нэмэр, байр суурийг товч танилцууллаа. Үүний зэрэгцээ хөгжлийн явцад оршиж байгаа асуудал ба бэрхшээлийг бас сэргэгээр таних хэрэгтэй. Үүнд: 1. Байгалийн баялаг болон бусад баялгаа нээн ашиглах төвшин өндөр биш. Дунд жижиг аж ахуйн нэгжүүдийн хөгжил хоцрогдонгуй, 2. Мал, тариалангийн зохион байгуулалт, нийгэмчлэлийн төвшин нэлээд доор, хөдөөгийн малжих, тариалах газрын хөрөнгө оруулалт хангалт муутай. Мал, тариалангийн үр ашгийн нэмэгдэл ба малчин, тариачны орлогын нэмэгдэл жич экологийн бүтээн байгуулалтын үүрэг хатуу бэрх, 3. Бүс нутгуудын хоорондын хөгжил харьцангуй ялгаатай. 4. Эдийн засгийн хөгжилтэй харьцуулбал хот хөдөөгийн оршин суугчдын орлого ялгаатайн дээр эдийн засгийн хөгжлийн хурдац нь орлогын нэмэгдэх хурдацтай уялдаа муу, Орлого багатай хүмүүсийн амьдрал хэцүү бэрхийн дээр ажлын байр бий болгох ба нийгмийн баталгаа муу зэрэг нийгмийн хүчин зүйл оршиж байна.

ӨЗО-ны Засгийн газар, шат бүрийн удирдах байгууллага ба ӨЗО-ны Хөгжилт Өөрчлөлтийн Комиссоос дээрх оршиж байгаа асуудлыг шийдвэрлэх, тулгамдаж байгаа хүчир бэрхшээлийг туулахад дараах таван ажлыг эрчимжүүлж, зохистой арга хэмжээ авахыг чухалчилж байна.

1. Мал тариалан, малжих тариалах орон, малчин тариачны асуудлыг дээд хэмжээгээр чухалчилж, тэтгэн дэмжих нормыг нэмэгдүүлж, мал тариалангийн үндсэн байр суурийг бэхжүүлж, малчин тариачдын орлогыг бодитойгоор нэмэгдүүлнэ.

2. Эх баялгийн давуулагтаа түшиглэж, аж үйлдвэрийн эдийн засгийг түргэн хөгжүүлж, орчин үеийн шинэхэн аж үйлдвэржилтийн явцаа түргэтгэнэ.

3. Үйлчилгээний салбарын хөгжлийг хурдасгаж, гуравдугаар аж үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлнэ.

4. Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, эдийн засгийн хөгжлийг хангана.

5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийг нэмэгдүүлж, социалист эе найрамдуу нийгмийг бүтээн байгуулна.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. Ян Зин: Засгийн газрын ажлын илтгэл. “Өвөр Монголын өдрийн сонин”. 2005 оны 1-р сарын 17-ны дугаар.
2. Өвөр Монголын Статистикийн Газрын бүртгэл: 2004 оны ӨМ эдийн засаг. “Өвөр Монголын өдрийн сонин”. 2005-оны 3-р сарын 5-ны дугаар.
3. Шүфан: Өвөр Монголын хүн нэг бүрд ногдох ДНБ нь Хятадын Баруун бус нутагт тэргүүн байрыг эзэлжээ. Өвөр Монголын “Умартын шин сонин”. 2005 оны 3-р сарын 7-ны дугаар.
4. Цэцэн: ӨМӨЗО-ны 2004 оны санхүүгийн нийт орлого “Өвөр Монголын өдрийн сонин”. 2005-оны 2-р сарын 6-ны дугаар.
5. Хай Чуан: Өвөр Монголын гадаад худалдааны нийт эргэлт 4 тэрбум. “Өвөр Монголын өдрийн сонин”. 2005-оны 2-р сарын 7-ны дугаар
6. ӨМӨЗО-ны хувийн хэвшлийн аж ахуй “Хятадын үйлдвэр худалдаа сонин” 2005-оны 2-р сарын 27-ны дугаар
7. Тан Юу Лан: Мэнню корпорацийн гайхамшиг. “Өвөр Монголын өдрийн сонин” 2005 оны 4-р сарын 8-ны дугаар